

Өмчийн тэмдэглэгээ анх Монголд үүссэн

First Asset Recording System Originated in Mongolia

Л. Мөнх-Очир¹

Хураангуй

Өгүүлэлд нягтлан бодох бүртгэлийн түүх судлаачдын олон улсын байгууллагын үйл ажиллагаа, дэлхийн улс орнуудад нягтлан бодох бүртгэлийн судалгаа хэрхэн хөгжиж байгаа, манай орны хувьд түүхийн энэ чиглэлийн судалгааны өнөөгийн төлөв байдлыг товч харуулж, дэлхийд монголчууд адууг анх гаршуулж гэршүүлсэн гэсэн таамгийг өөр өөрсдийн байр сууринаас баталсан гадаадын болон өөрийн орны эрдэмтдийн судалгааны дүгнэлтэд үндэслэн монголчууд өөрсдийн өмч болох адууг бусдаас ялгахын тулд чихийг нь имнэж, овгийнхоо сүлд тэмдгийг тамга болгон биенд нь хайрснаар энэ нь түүхэнд өмчийн анхны тэмдэглээ төдийгүй энгийн бүртгэлийн эхний элементийг бий болгож бүртгэлийн үүсэлд түүхэн үүрэг гүйцэтгэсэн гэсэн санааг дэвшүүлсэн болно.

Түлхүүр үгс: нягтлан бодох бүртгэлийн түүх судлал, ядуучуудыг тэтгэх сан, ертөө, жас жавын аж ахуй, адууг гаршуулж гэршүүлэх, өмчийн тэмдэглээ, овгийн сүлд, им, тамга, энгийн бүртгэл, энгийн бүртгэлийн анхдагч элемент

Abstract

The paper outlines how the international economic history association operates, how the global accounting historian study evolving, and the current condition of the Mongolian accounting historian research developments. The findings are based on the assumption of Mongolia is the first nation who tamed the wild horses for domestic use, therefore, to distinguish the livestock from one to another, the ears of the horses are marked with different patterned cuts. The paper suggests a conclusion that these cuts were not only the first asset recording system but also the first element of bookkeeping in accounting history.

Keywords: study of accounting history, charity fund for poor people, horse relay station, адууг гаршуулж гэршүүлэх, tame the wild horses, asset recording, tribe symbol, stamp, simple bookkeeping, first element of bookkeeping

¹ МУИС-БС, Нягтлан бодох бүртгэлийн тэнхим, доктор
E-mail: lmunkhochir@yahoo.com

Улс орнуудад нягтлан бодох бүртгэлийн түүх судлал нэлээд эртнээс эхэлсэн бөгөөд энэ нь олон улсын хэмжээний асуудал болж, хүрээ нь өргөжин тэлсээр ирсний жишээ бол нягтлан бодох бүртгэлийн түүх судлалын нэртэй эрдэмтэн Ernest Stevelinck²-ийн санаачлагаар анх 1970 онд Нягтлан бодох бүртгэлийн түүх судлаачдын дэлхийн их хурал Бельги улсын Брюссель хотод болсноос хойш хамгийн сүүлд 2016 онд Италийн Пескара хотод хуралдсан XIV их хурлаас ээлжит XV их хурлыг 2020 оны 7-р сард ОХУ-ын Санкт-Петербург хотод хийхээр тогтсон юм.

АНУ-ын нэрт эрдэмтэн, нягтлан бодох бүртгэлийн түүх судлаач Gary John Previts³-ийн санаачлагаар 1973 онд Нягтлан Бодох Бүртгэлийн Түүх Судлаачдын Олон Улсын Академи байгуулагдан нягтлан бодох бүртгэлийн түүхийн судлалаар олон улсад идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна.

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын байгууллага (IFAC)-ын зүгээс нягтлан бодох бүртгэлийн түүхийн судлалын талаар ихээхэн анхаарч, 2002 онд болсон Дэлхийн нягтлан бодогчдын XIV их хурлаасаа улс орон бүр нягтлан бодох бүртгэлийн түүхээ эрчимтэй судлах талаар уриалга гаргасан нь нягтлан бодох бүртгэлийн түүх судлал дэлхий нийтийн хэмжээнд чухал асуудал болохыг харуулж буй хэрэг юм.

Даяаршлын үр дүнд нягтлан бодох

² Эрнест Стевелинк (1909-2001) нягтлан бодох бүртгэлийн түүх судлалын нэрт эрдэмтэн, Нягтлан Бодох Бүртгэлийн Түүх Судлаачдын Олон Улсын Академийн байнгын гишүүн, нягтлан бодох бүртгэлийн түүх судлалаар дэлхийд хувь нэмэр оруулсны төлөө олгодог дээд шагналын эзэн, Луко Пачолигийн намтар, түүний гол бүтээл болох дансны давхар бичилтийн талаар олон ном хэвлүүлсэн Бельги улсын иргэн.

³ Гари Джон Превиц. АНУ-ын нягтлан бодох бүртгэлийн түүхийн нэрт судлаач, энэ чиглэлээр олон арван ном, өгүүлэл бичсэн, өөрийн орны төдийгүй Английн Оксфордын их сургууль, Шотландын Эдинбургийн их сургууль зэрэг гадаад дотоодын хэд хэдэн сургуульд нягтлан бодох бүртгэл, түүний түүхийг зааж ирсэн нэртэй багш, доктор профессор.

бүртгэл улс орнуудын бизнесийн хэл болж, үндэсний төдийгүй дэлхий нийтийн ач холбогдол нь улам өсөн нэмэгдсээр байна. Нягтлан бодох бүртгэлийг эртний хүмүүс хоол хүнсээ олох, түүнийг нөөцлөх, тариа тарих, зэрлэг амьтдыг гаршуулж гэршүүлэн ахуй амьдралдаа хэрэглэх болсон тэр цаг үеэс үндэс суурь нь тавигдсан эртний түүхтэй шинжлэх ухаануудын нэг гэж бүртгэлийн түүх судлаачид үздэг. Аль ч ард түмэн, улс орнуудын хувьд бүртгэл үүссэн түүх байх нь мэдээж бөгөөд эртнээс бүрэлдэн тогтсон, урт удаан хугацааны түүхтэй Монгол орны хувьд бүртгэл нь мөн л эрт үед үүссэн байх нь ойлгомжтой.

Манай орны хувьд нягтлан бодох бүртгэлийг 1921 оны ардын хувьсгал ялснаар үйлдвэр, аж ахуйн байгууллагууд бий болсон тэр цагаас үүссэн гэж үздэг бөгөөд нягтлан бодох бүртгэлийн түүхийн судалгаа ч мөн энэ цаг үеэр хязгаарлагддаг болох нь нягтлан бодох бүртгэлийн холбогдох ном, сурах бичиг, илтгэл, өгүүллийн агуулгаас тодорхой харагддаг. Үүнд тухайн үеийн нийгмийн үзэл суртал ч нөлөөлж байсан нь ойлгомжтой. Энэ цаг үеэс урагш одоогийн нягтлан бодох бүртгэлийн үндэс суурь болох түүний элементүүд анх хэрхэн үүссэн талаар хийгдсэн иж бүрэн шинжтэй, дорвитой судалгаа өнөөдрийг хүртэл хийгдээгүй гэдэгтэй энэ салбарын эрдэмтэн судлаачид, түүхчид санал нийлэх байх.

Манай орны эрт үеийн бүртгэлийн үүсэл, түүнийг судлах талаар С.Лодой, Т.Жааваа, Ц.Гунгаанямбуу, Л.Дондог, Л.Мөнх-Очир, А.Өнөржаргал, Д.Моломжамц нарын эрдэмтэн, судлаачид өөрсдийн бүтээлдээ хөндсөн юм.

Нягтлан бодох бүртгэл судлалын төлөв байдал, түүнийг судлахын ач холбогдлын талаар эрдэмтэд, судлаачдын байр суурийг авч үзвэл Т.Жааваа (2003) “Манайд үндэсний тоо бүртгэлийн үүсэл, хөгжлийн дорвитой судалгаа одоо хэр үгүйлэгдсээр буй. Үндэсний санхүү, бүртгэлийн албаны хөгжлийн түүхийг Автономитын үеэр хязгаарлах бус, түүнээс өмнөх үеийг

хамарч судлах эрэлт их бий” гэсэн байна.

Доцент С.Лодой (2009) “Монгол улсад бүртгэл үүсч хөгжсөн түүхийг XVIII-XIX зууны үеэс, болдогсон бол XV зууны үеэс, тэр бүү хэл эзэн Чингисийн их гүрний үеэс судалмаар юм. Эзэнт их гүрний үед төр засаг өндөр түвшинд зохион байгуулагдсан, хууль ёс чанга нарийн дэг журамтай байсныг бодоход төрийн сан, үндэсний баялагийн бүртгэл тооцоо өвөрмөц аргаар хэрэгжиж байсан нь мэдээж. ... Энэ бүхнээс үзэхэд манай санхүү, бүртгэлийн эрдэмтэн, мэргэжилтэн нар нь түүхчид, бусад чиглэлийн судлаачидтай хамтран ажиллавал үр дүнтэй болно гэж бодогдох юм” гэсэн нь эрт үеэс манай оронд бүртгэлийн үүсэл, хөгжлийн хангалттай судлагдахуун байгаа гэдгийг харуулахын зэрэгцээ түүнийг судлахын чухлыг онцолжээ.

Эрдэмтэн Л.Дондог (2016) манай оронд бүртгэл үүссэн түүхийг “Нягтлан бодох бүртгэлийн түүх” номын “Монгол нутаг дээрх эртний улсуудын нягтлан бодох бүртгэл” бүлэгтээ хадан дээр зосоор зурах эсвэл сийлэх байдлаар тэмдэглэсэн дөрвөлжин хашлагын доторх олон цэгэн дүрс, стандарт дүрсүүдийг бүртгэлийн тэмдэглээ буюу мал, эсвэл эд зүйлсийн тоо байж магадгүй гэсэн эрдэмтэн Ц.Гунгаанямбуугийн таамгийг дэмжиж, Хүннүгийн үеийн яс, модонд гаргасан хэрчлээст тэмдэглээ бүхий мал, хөрөнгийн бүртгэл, төлбөрийн хэрэгслийн үүсэл, Их Монгол улсын үеийн бүртгэл, сүм хийдийн бүртгэлийн талаар түүхэн баримтад тулгуурлан авч үзсэн нь манай орны бүртгэлийн эрт үеийн түүхийг өгүүлсэн анхны бүтээл болсноороо нягтлан бодох бүртгэлийн түүхийн судалгаанд үнэтэй хувь нэмэр болох нь дамжиггүй.

Бүртгэлийн үүслийг анх хамгийн эрт үед хамаатуулж, түүхэн баримт түшиглэн өөрийн таамгийг дэвшүүлсэн эрдэмтэд бол Ц.Гунгаанямбуу, Т.Жааваа нар юм. Ц.Гунгаанямбуу (2006) доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээлдээ “Монголын тал хөндийд түгээмэл оршин

буй маш олон хадны зосон, сүг зургийн бүтээц ба зохиомжийг ажиглахад элдэв хүн, мал, амьтад дүрслээгүй, харин цэг, толбо, ац, хэрээс, тууш зураас, бүтэн зуйван, хагас саран, дөрвөлжин, мөр (амьтны), хээ, дардас зэрэг ямар нэг утга санааг кодчилсон стандарт дүрс ба тэмдгүүд зонхилж сийлэгдсэн нь бидний зүгээс эртний (болхи) тэмдэглэгээ буюу данс бичилтийн ул мөр гэсэн таамаг дэвшүүлэхэд хүргэж байна” гэсэн нь бүртгэлийн үүслийн талаар дэвшүүлсэн сонирхол татахуйц таамаг байж болох юм.

Л.Мөнх-Очир, А.Өнөржаргал нар манай орны бүртгэлийн үүслийг овгуудад өмч бий болсон цаг үетэй холбон авч үзэж, энэ асуудлаар гадаадын болон дотоодын олон улсын эрдэм шинжилгээний хурлуудад илтгэл тавьж хэлэлцүүлсэн нь бүхэлдээ бүртгэлийн түүх судлалд зориулагдсанаараа онцлог юм.

Монголчууд адууг гаршуулж гэршүүлснээр анх нүүдэлчин омгуудын дунд өмч үүсэн, түүнийгээ бусдаас ялгахын тулд тэмдэглэх болж, улмаар нүүдлийн мал аж ауй, газар тариалан эрхлэх болсон, хожим улсын сангаас үгээгүй ядуучуудыг тэтгэх сан, өртөө байгуулсан, алт мөнгөн зоос, цаасан мөнгө гаргасан, Хархорумд мөнгөний хэрэг эрхлэх газар (банк) байгуулсан, хоёр тивийг холбосон олон улсын арилжаа наймааны зам дайран өнгөрдөг байсан, сүм хийдүүдэд жас жавын аж ахуй бий болсон зэрэг нь бүртгэл үүсэх, хөгжих зайлшгүй чухал нөхцөл мөн төдийгүй энгийн бүртгэл хөтлөгдөж байсан нь гарцаагүй боловч харамсалтай нь эдгээрт холбогдох түүхэн баримт бичиг бараг үлдсэнгүй. Энэ нь манай орны нягтлан бодох бүртгэлийн түүхийг судлахад оршиж байгаа хамгийн гол бэрхшээл юм. Гэсэн хэдий ч цөөн боловч өөрийн улс оронд болон бусад улсад хадгалагдаж байгаа монголын түүхэнд холбогдох баримт бичиг, археологийн олдвор зэрэгт үндэслэн нягтлан бодох бүртгэл, энгийн бүртгэлийн түүхийг судлах боломж байж болмоор санагдана.

Монгол орон уснаас цухуйж гарсан хамгийн анхны хуурай газрын нэг тул зарим эрдэмтэд Монгол орон эртний хүн үүссэн өлгий нутаг байж болох тухай таамгийг эртнээс дэвшүүлж, Америкийн эрдэмтэн H.F.Osborn, R.C.Andrews нар эртний хүн Монголд үүссэн гэж үзэн, 1920-иод оны үед Монголын говьд судалгаа хийсэн ч үүнийг батлах нотолгоо олоогүй. Гэсэн хэдий ч хүний үүслийн олон салбарт хийгдсэн судалгаагаар орчин үед Монголд хүн анх үүссэн байж болзошгүй гэсэн таамгийн үндэслэл нэмэгдсээр байгаа талаар эрдэмтэд, судлаачид багагүй ярьж бичих болсон юм байна.

Монгол газар нутаг, монголчууд олон зүйлээр дэлхийд анхдагч. Тэдгээрийн нэг нь мөнгө, санхүүтэй холбоотой асуудал бөгөөд үүсэж бий болсон цагаасаа нүүдлийн аж ахуй эрхэлж байсан улс үндэстний хувьд дэлхий нийтэд энэ нь ихээхэн сонирхол татсан асуудал байж болох юм. Хүннү, Түрэг, Уйгар улсын үеэс монголчууд зоосон мөнгө цутган арилжаа наймаанд хэрэглэж байсан баримт цөөнгүй. Их эзэн Чингэс хаан Монголын нэгдсэн тулгар төрийг байгуулан “Сүхэс” нэртэй алт, мөнгөн зоос цутгуулж, улмаар 1227 онд дэлхийд анх удаа цаасан мөнгө хэвлүүлэн гүйлгээнд гаргаж байсан, хүн төрөлхтний түүхэнд морин өртөө байгуулсан нь анхдагч байсан зэрэг олон баримт байдаг талаар түүхийн баримт бичигт тэмдэглэгджээ. Эдгээртэй холбогдсон бүртгэл хөтлөгдөж байсан нь ойлгомжтой бөгөөд мөнгө төлбөрийн хэрэгсэл болсон нь бүртгэлийн нэгэн шинэ төрөл, шинэ үе шатыг үүсгэн нягтлан бодох бүртгэлийн хөгжилд эргэлт гаргасан хэмээн судлаачид үздэгийн зэрэгцээ өнөөдрийг хүртэл дэлхий нийтээр нягтлан бодох бүртгэлд ажил гүйлгээг мөнгөөр илэрхийлэн бүртгэж байгаа билээ.

Нягтлан бодох бүртгэл хамгийн энгийн хэлбэрээс өнөөгийн бүртгэл тайлагналын тогтолцоо болтлоо хөгжсөн түүхийг бусад шинжлэх ухаануудтай зэрэгцүүлж үзвэл хүн төрөлхтөний хөгжлийн түүхэнд урт замыг туулсан гэдэг нь ойлгомжтой юм.

Өөрөөр хэлбэл хүн төрөлхтөн үүсэн, хамтаараа амьдрах болж, хүнс тэжээлээ олж бэлтгэж эхэлсэн тэр үеэс аж ахуйн бүртгэлийн хэрэгцээ бий болсон гэж АНУ-ын эрдэмтэн M.R.Mathews, M.H.V.Perera, ОХУ-ын судлаач, бүртгэлийн түүх судлалаар нэрд гарсан эрдэмтэн Я.В.Соколов, В.Я.Соколов, Т.Н.Малькова, Францын эрдэмтэн Jacques Richard нарын эрдэмтэд, судлаачид үздэг. Энгийн бүртгэлийн систем буюу аж ахуйн бүртгэл, тэр дундаа “агуулахын бүртгэл” нь нягтлан бодох бүртгэлийн эхлэлийг тавьсан гэж эрдэмтэд, судлаачид үзсэн байх бөгөөд “агуулахын бүртгэл” нь анхнаасаа хяналтын үүрэгтэй байсан тухай Италийн судлаач Fabio Besta (1845-1923) өгүүлжээ (Риполь-Сарагоси & Реутов, 2006).

Хүмүүс нэгэнт бий болгосон болон олж цуглуулсан эд зүйлсийнхээ заримыг нөөцлөх, хадгалах, дахин олж авахын хэрээр нөөц нь нэмэгдэж бас хэрэглэсэн хэмжээгээр багасан хөдөлгөөнд орж, үлдэгдлийг омгийн ахлагч цээжээр тогтоодог байснаа хүмүүс олноор амьдрах болж, хэрэглээ нэмэгдэхийн хэрээр үлдэгдлийг тоолох, түүнийгээ чулуу, мод, навчин дээр тэмдэглэдэг болсныг бүртгэлийн түүхэнд дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг (Лупиков, 2006). Энэ бол бүртгэл үүссэн эхний шат байсан ба эртний хүмүүс өөрийн энэхүү хэрэглээг анх удаа мод, чулуу, навч, тусгайлан бэлтгэсэн шавар дээр тэмдэглэх болсноор бүртгэлийн бичмэл мэдээлэл үүсэх эхлэл тавигджээ.

Харин бүртгэлийн илүү боловсронгуй хэлбэрийг бий болгосон орон бол эртний Египет, Грек, Рим бөгөөд судлаачид эртний Египетийг нягтлан бодох бүртгэлийн өлгий нутаг гэж үздэг. Эдгээр оронд газар хагалж тариа тарих үйл ажиллагаа нь бүртгэлийн хөгжилд түлхэц үзүүлсэн. Тухайлбал газраа хэмжих, будаа тариаг нөөцлөн хадгалах, түүнийгээ хэмжин тоолох зэргээс агуулахын нэлээд боловсронгуй бүртгэл үүссэн. Газар тариалан эрхлэгчдийн хувьд хөдөлмөрийн үндсэн хэрэгсэл нь анжис, газар, үр дүн нь авсан ургац байсан бол зэрлэг амьтдыг

гаршуулан тэжээдэг байснаа гэрийн болгон тэдгээрийг өөрсдийн хэрэгцээнд ашиглан ашиг шимийг нь хүртэж, тэр нь аж ахуйн шинжийг олж малыг улмаар өмчлөх болсон малчин (мал аж ахуй эрхэлдэг) овгуудын хувьд эртнээс хэрэглэж ирсэн овгийн бэлэг тэмдгийг илэрхийлсэн дүрсээр малаа тамгалах болсон нь нэг талаар өөрийн өмчлөлийг тогтоосон хэрэг, нөгөө талаар энэ нь өөрийн мал сүргийг ялган таних хяналт байжээ гэж үзэж болох юм.

Нэрт судлаач, эрдэмтэн Х.Пэрлээ (1965) “Дэлхийн олон угсаатан ард түмний овгийн түүхээс үзэхэд, тэдний харилцан холбогдох харь элэгтэн, халуун садангаа ялган мэдэх олон бэлэг тэмдэгтэй байжээ. Жишээлэхэд монголчуудад уг, ураг, удам гарал, овог ястан, махан төрөл, ясан төрөл, гарваль, төрвөл гэж ялган үзэх ёсон тогтож овгийн сүлд, овгийн шүтлэг, ... овгийн тулалдааны уриа хашгираа тус тусдаа байсны гадна овгийн им тамга гэж нэгэн чухал бэлэг тэмдэг байжээ” гээд... монголын түүхийн үе үед олон аймагтан, удамтан оршин суусан бөгөөд, тэд Рашаан хад, түүний дэргэдэх хадан самбар, тусгай ханан хад, үхэр чулуунд овгийн тамгаа удаа дараагаар сийлж үлдээсэн гэж болно” хэмээн өгүүлжээ. Тамгыг овгийн бэлэгдэл, бусдаас ялган таних тэмдэг болгон хэрэглэснээс нэлээд хожуу малд дарах болсон байна. Энэ тухай уг бүтээлд “Хүн төмөрлөг багаж, эдлэлтэй болсон цагаас буюу адгуусан амьтан гаршуулах, гэршүүлэх, малжих аж төрөл дэлгэрэхийн хамт, им тамганы тоо олширч, адуусанд улайтган хайрах тамга үзэгдэж эхэлсэн бололтой” гэжээ.

Малын им, тамга нь монголчуудын өмчийн тэмдэг байсан тухай академич Б.Ринчин 1954 онд (Rintchen, 1954) “Монголчуудын өмчийн тэмдэг” хэмээх өгүүлэл бичиж Чехословакийн “Архив Ориентални” сэтгүүлд нийтлүүлжээ. Өмчийн тэмдэглэгээ болох малын тамганаас өмнө малыг имнэж тэмдэглэж байсан баримт нь өөрийн өмч хөрөнгийн бүртгэл хяналтын түүхийг тодорхой хугацаагаар урагшлуулж

байгаа зүйл гэж үзэх үндэстэй.

Эрдэмтэн Х.Пэрлээ (1965) “Монголчуудын малын байнгын дарсан (хайрсан) тамганаас гадна, бас нэгэн сонин тэмдэглэгээ байдаг юм. Түүнийг малын им гэдэг. Имийг хайрлага тамганаас өмнө үүсэн гарсан гэж эрдэмтэн нар үзжээ. Им бол овгийн нэн эртний тэмдгийн (тамганы) үлдэц гэдэг нь үнэнтэй хэрэг ажээ” хэмээн өгүүлжээ. Эндээс им тамгыг овог удмын өвөрмөц онцлогийг тусгасан өөрийн өмч хөрөнгөө тэмдэглэх энгийн бүртгэлийн эртний хэлбэр гэж үзэж болох юм. Эдгээр түүхэн баримтууд нь нүүдэлчин овгийн дунд хөрөнгийн бүртгэл нэлээд эртнээс үүссэнийг илтгэж байна.

Хөрөнгийн бүртгэл, хяналтын хамгийн эртний арга бол тооллого мөн. Бүртгэлийн энэ аргыг хэрэгжүүлэхийн тулд бие биенээс нь ялган таних, тухайн хүний өмч хөрөнгө мөн болохыг нотлох зорилгоор байнгын шинжтэй тусгай тэмдэглээг уг хөрөнгөнд хийснээр сая тоолох, бүртгэх боломж бүрдэнэ. Энэ нь хөрөнгийн төрлөөс хамаарч өөр өөр байх боловч малын хувьд чихний им болон биенд нь хайрсан тамга өнөөг хүртэл олон мянган жилийн турш хэрэглэгдсээр иржээ. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед Монгол улсын хэмжээгээр бүх сумдын нэгдлийг тогтсон им, тамгатай болгож түүнийг нь ХАА-н яам албан ёсоор баталгаажуулан шийдвэр гаргаж байсан баримт бий.

Монголчууд анх адууг гаршуулж гэршүүлсэн гэдэг нь эрдэмтдийн судалгаагаар улам бүр нотлогдох болсон бөгөөд энэ нь овгуудад өмч үүсэх эхлэл болж, улмаар энэхүү өмчийг бусдаас ялгахын тулд хэрэглэсэн им, тамга нь нэг талаас өмчийн тэмдэглээ мөн боловч нөгөө талаасаа энэ нь энгийн бүртгэлийн эхний элемент байжээ гэж үзэх үндэстэй.

Дүгнэлт

- Дэлхий нийтээр улс орнууд өөрсдийн нягтлан бодох бүртгэлийн түүхийг судлах нэр их ажил энэ салбарын өнөөгийн онцлог болон өрнөж

- байна. Энэ бүхнийг зангидсан олон улсын байгууллагууд бий болж үйл ажиллагаа нь жилээс жилд өргөжин тэлсээр байна.
- Манай орны хувьд нягтлан бодох бүртгэлийн түүхийн дорвитой судалгаа өнөөг хүртэл үгүйлэгдсээр байгаа, гэтэл түүхэнд анх нүүдэлчдийн төрт улсыг байгуулсан, Их Монгол улсыг цогцлоож зоосон болон цаасан мөнгө гаргасан зэрэг улс оронд бий болсон олон түүхэн үйл явдлуудтай холбож үзвэл бүртгэл тооцоо ямар нэг байдлаар хэрэгжиж байсан нь мэдээж тухай зарим эрдэмтэд, судлаачид өгүүлжээ. Энэ нь бүртгэлийн түүхийн судлагдахуун Монгол орны үүсэл, хөгжлийн аль ч үед хангалттай болохыг харуулж буй хэрэг мөн.
 - Монголчууд анх адууг гаршуулж гэршүүлснээр мал ахуй эрхлэх болж, улмаар өмч үүсэн түүнийгээ бусдаас ялгахын тулд өвөрмөц тэмдэглэгээ хэрэглэсэн нь малын им, тамга бөгөөд энэ нь энгийн бүртгэлийн анхдагч элемент болон хөгжиж иржээ. Өмчийн энэ тэмдэглэгээг хүн төрөлхтний түүхэнд анх монголчууд бий болгосон гэж үзэх үндэстэй. Эртний улс орны нэг, олон мянган жил нүүдэлчдийн өвөрмөц өв соёлыг тээсээр ирсэн манай орны хувьд дэлхийн бусад орны өнөөгийн жишгээр бүртгэлийн түүхээ гүнзгий судлах шаардлага байгааг эрхгүй анхааран, холбогдох байгууллага, салбарын эрдэмтэд, судлаачид, түүхчид, мэргэжилтнүүд нэгийг бодож хоёрыг тунгаах цаг аль хэдийнээ иржээ.

Ашигласан материал

- Rintchen, Bi. (1954). Les Signes de Propriete Chez Les Mongols. *Archiv Orientalni*, 22, 467-473.
- Лупиков, Е. В. (2006). *История бухгалтерского учета*. Москва.
- Риполь-Сарагоси, Ф. Б., Реутов, В. Ю. (2006). *Внутренний аудит: организация и планирование*. Ростов-на-Дону.
- Соколов, Я. В. (1985). *История развития бухгалтерского учета*. Москва.
- Гунгаанямбуу, Ц. (2006). *Санхүүгийн тайлагнал, удирдлагын бүртгэлийн онолын зарим асуудал*. Улаанбаатар.
- Дондог, Л. (2016). *Нягтлан бодох бүртгэлийн түүх*. Улаанбаатар.
- Жааваа, Т. (2003). *Үндэсний бүртгэлийн тогтолцоог шинэчлэх асуудал, шинжлэх ухааны докторын зэрэг горилсон диссертаци*.
- Лодой, С. (2009). *Нягтлан бодох бүртгэлийн хөгжлийн замнал*. Улаанбаатар.
- Мөнх-Очир, Л., Өнөржаргал, А. (2017). Исторические аспекты развития бухгалтерского учета в Монголии. *Международный экономический симпозиум*, Санкт-Петербург, Россия, 20-22 Апреля.
- Мөнх-Очир, Л., Өнөржаргал, А. (2018). Бүртгэлийн түүхэн хөгжил, үечлэлийн асуудал. *НББ-ийн тэнхимийн 50 жилд зориулсан Олон улсын эрдэм шинжилгээний хурал*, Улаанбаатар.
- Пэрлээ, Х. (1965). *Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь*. Улаанбаатар.
- <http://www.aahhq.org>